



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/351

Мөрөн сум

Орон нутгийн болон улсын чанартай
авто замын дагуух хог хаягдлын цэвэрлэгээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны 02 албан даалгавар, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 07 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Аялал жуулчлалын улирал эхэлсэнтэй холбогдуулан авто зам дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлын ерөнхий удирдамжийг нэгдүгээр, хуваарийг хоёрдугаар, тайлан ирүүлэх хүснэгтийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аймгийн хэмжээнд авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлын хүрээнд сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж, холбогдох тайлан мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

4. Авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сум бүр үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт болон хариуцсан байгууллагын дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

671 0010741

Аймгийн Засаг даргын 2023 оны 06
дугаар сарын 20-ний өдрийн А/351 тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт

**САЙДЫН 02 АЛБАН ДААЛГАВАР, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 07 АЛБАН
ДААЛГАВРЫН ХҮРЭЭНД ОРОН НУТГИЙН БОЛОН УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО
ЗАМЫН ДАГУУХ БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Зорилго. Хог хаягдлын тухай хуулийн 9.4.3-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, амралт, аялал жуулчлалын улиралд зам дагуух үүссэн хогийг цэвэрлэхэд бүх нийтийг татан оролцуулах, Хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, байгальд ул мөргүй аялах уриалгыг хүргэх, иргэдийн хандлагыг өөрчлөхөд оршино.

Хугацаа. 2023 оны 06 дугаар сарын 23

Зохион байгуулагч: АЗДТГазар, БОАЖГ

Хамрах хүрээ. Аймгийн төрийн болон төр, орон нутгийн өмчит бүх хэлтэс агентлаг, байгууллага, бүх сумдын ЗДТГ, иргэд, ААНБ, оролцоно.


Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Сумдууд захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан хуваарьт үндэслэн авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх хуваарийг гаргаж хамтран ажиллах байгууллагат хүргүүлсэн байна.
- Тариалын сумын газар нутагт хамаарах хэсгээс Хатгал тосгон хүртэлх засмал замын дагуу хогийг цэвэрлэх /замын 2 талруу 50 м доторх/
- Тухайн сумын Байгаль хамгаалагч авто зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээнд тухай бүр хяналт тавьж ажиллана.
- Бусад сум мөн сумын нутгаас аймгийн төв хүртэлх өөрийн сумын нутагт харъяалах сум хоорондын зам дагуух хогийг цэвэрлэнэ.
- Замын дагуух газрыг байгууллагуудад хуваарилж өгсөн хуваарийн дагуу цэвэрлэж, хяналт тавьж, хариуцан ажиллах байгууллагадаа мэдээг өгнө.
- Хог хаягдлын тухай хуулийг сурталчилах, "Хоггүй Хөвсгөл" хог хаягдлыг зөвлөгөөнөөс гарсан уриалгыг олон нийтэд уриалах, нөлөөллийн ажил
- Цэвэрлэсэн хогийг тухайн сумын хог тээврийн машин явж ачин хогийн цэгт хүргэнэ. Хог хаягдлыг шатаахыг хориглоно.
- Цэвэрлэсэн хог болон хогноос хуванцар сав, шил, лаазыг ангилан ялгаж, хоёрдогч түүхий эдийн цэгт тушааж, мэдээг хариуцан ажиллаж байгаа байгууллагад өгнө.
- Зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хуваарилсан хуваарийн дагуу холбогдох байгууллагууд ажиллаж, БОАЖГ-т мэдээгээ хүргүүлнэ.


Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 20-ний өдрийн А/х/гоот
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗАМ ДАГУУ ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ ХУВААРЬ

№	Цэвэрлэх талбай	Хариуцан цэвэрлэх байгууллага	Хог ачих машин	Хамтран оролцох байгууллага	Хяналт тавих ажлын хэсгийн гишүүн
1	Тариалан сумын нутагт хамаарах замын хэсэг	Тариалан сумын ЗДТГ, иргэд ААНБ-ууд	Тариалан сумын хог тээврийн машин	БОАЖГ, ХХААГ, Мал эмнэлэгийн газар, Хөвсгөл-Эрчим хүч ХХК Музей, Номын сан, Мэдээлэл сүлжээ холбоо ТӨК	П.Мөнхжаргал БОАЖГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
2	Их-Уул сумын нутагт хамрагдах замын хэсэг	Их-Уул сумын ЗДТГ, иргэд ААНБ-ууд	Их-Уул сумын хог тээврийн машин	Дэлгэрмөрөн голын СГЗахиргаа, Статистикийн хэлтэс, Дулааны станц ТӨК, Улсын бүртгэлийн хэлтэс, Тагнуулын хэлтэс	Б.Энхгэрэл Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
3	Түнэл сумын нутагт хамрагдах замын хэсэг	Түнэл сумын ЗДТГ, иргэд, ААНБ	Түнэл сумын хог тээврийн машин	УЦУОШТөв, Биеийн тамир спортын газар, Орон нутгийн өмчийн газар, Гаалийн алба, Авто тээврийн төв, аймгийн Аудитын газар, МСҮТөв	Д.Өнөрбат УЦУОШТөвийн дарга
4	Тосонцэнгэл сумын нутагт хамрагдах замын хэсэг	Тосонцэнгэл сумын ЗДТГ, иргэд ААНБ-ууд	Тосонцэнгэл сумын хог тээврийн машин	Аймгийн ИТХ, АЗДТГ, ГХБХБГазар, Хилийн цэргийн анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Эрүүл мэндийн газар, Хөвсгөл Ус суваг ХХК, Хөгжимт драмын театр	Б.Ганзориг ГХБХБГазрын дарга
5	Мөрөн сумын нутагт хамрагдах замын хэсэг	ХТҮТөв, Мөрөн сумын ЗДТГ,	ХТҮТөвийн машин	Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК, ХХҮГазар, Боловсрол шинжлэх ухааны азар, Мөрөн сумын бүх сургууль, цэцэрлэгүүдийн албан хаагчид, Шүүх, прокурор, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн газар	С.Мөнх-Эрдэнэ Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ний захирал
6	Алаг-Эрдэнэ сумын нутагт хамрагдах замын хэсэг	Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ, иргэд, ААНБ-ууд	Алаг-Эрдэнэ сумын хогны машин	Татварын хэлтэс, ОБГ, Нийгмийн даатгалын хэлтэс, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар, Стандартчилал хэмжилзүйн хэлтэс	Ч.Хуншагай Татварын хэлтэсийн дарга



ЗАМ ДАГУУХ ЦЭВЭРЛЭГЭЭНД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ
БАЙГУУЛАГУУДЫН ХУВААРЬ



2023 оны 06 дугаар
20-ний өдрийн АЗХТ-оот
ийн гуравдугаар хавсралт

[illegible]

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
---	---	---	---	---	---	---	---	---	----	----